



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/207

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Мандалговь хотын I, II хэлхээний дулаан хангамжийн горимын тооцоо, дулаан алдагдлын аудит" зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Б.Буманбаатар (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

И.Эрдэнэцог (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Э.Дэлгэрбуян (Сайнцагаан сумын 2 дугаар сургуулийн нягтлан бодогч)

Нарийн бичиг:

М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Уянга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4803100592